



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/95

Арвайхээр сум

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 12 дугаар багт “Арьс Ирээдүй” ХХК-ний захиалгаар баригдсан арьс ширний үйлдвэрийн барилга угсралтын ажил дууссан тул “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу дунд төвөгшилтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дарга (Т.Ариунболд)-д даалгасугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0189

Аймгийн Засаг даргын 2024 оны 15 дүгээр
сарын 07-ны өдрийн 15 дугаар
захирамжийн хавсралт



**ДУНД ТӨВӨГШИЛТЭЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ
АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Комиссын дарга: Т.Ариунболд (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)

Гишүүд: С.Нямдорж (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч)

Ц.Нэргүй (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Г.Сүрэнжав (Өвөрхангай аймгийн Онцгой байдлын хэлтэсийн гамшигаас хамгаалах хяналтын улсын ахлах байцаагч)

Б.Энхболд (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Стандарт, хэмжил зүйн хэлтсийн хэмжил зүйн хяналтын улсын байцаагч)

Д.Чинзориг ("Онги-Ус суваг" ОНӨААТҮГ-ын ашиглалтын инженер)

М.Багаажав (Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн Өвөрхангай аймаг дахь салбарын Ерөнхий инженер)

Г.Баасансүрэн ("Монголын мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-ийн Өвөрхангай аймаг газрын кабель шугамын инженер)

Т.Гал-Эрдэнэ (Арвайхээр сумын Захирагчийн албаны Ерөнхий менежер)

Л.Цэнд-Аюуш ("Жигүүрт хөлөг" ХХК-ийн захирал)

Нарийн бичгийн дарга: Ц.Нямдалай (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын ахлах мэргэжилтэн)

Б.Хэрлэн (Арвайхээр сумын Зүлэгтийн 12 дугаар баг)